



ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГА А.БУЯНБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.10.27 № 01/154

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны 2016 оны 3 дугаар улиралын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 36,423,479.19 /Гучин зургаан сая дөрвөн зуун хорин гурван мянга дөрвөн зуун далан есөн / төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Нийт 7,010,266.00 төгрөгийн гадны авто машин ашиглахдаа гэрээ байгуулаагүй шатахууныг батлагдсан жишиг нормыг үндэслэн шатахуун зарцуулалтын тооцоог бодоогүй, акт үйлдэж баталгаажуулаагүй.

Энэ нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1-р хавсралт /автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/-д заасныг;

2. Аудитаар 29,413,213.19 төгрөгийн бараа материалын тооллого хийсэн боловч үлдэгдлийг данс бүрээр тооцоо бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2-т /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ заасныг зөрчсөн.

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг

1700600712

арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол улсын Ерөнхий аудитын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Гадны авто машин ашиглахдаа гэрээ байгуулаагүй шатахууныг батлагдсан жишиг нормыг үндэслэн шатахуун зарцуулалтын тооцоог бодож тооцооны актаар баталгаажуулах
2. Бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийж данс тус бүрээр тооцоо бодож актаар баталгаажуулж байх,
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дүгээр сарын 01-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Шийдвэр гүйцэтгэх албаны дарга /А.Буянбаатар/, нягтлан бодогч /Г.Энхцэцэг/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Шинжээч



ЗӨВШӨӨРСӨН:


Шийдвэр гүйцэтгэх алба:

Дарга

А.Буянбаатар

Нягтлан бодогч

Г.Энхцэцэг



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.